

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ**



**2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2021 ОН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	3-4
1.1 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	
1.2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	
1.3 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	5
2.1 Засгийн газрын тогтоолын хэрэгжилт	
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	6-17
3.1 Дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт	
3.2 Архив, Албан хэрэг хөтлөлт	
3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	
3.4 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	18-20
4.1 Үйл ажиллагааны ил тод байдал	
4.2 Хүний нөөцийн ил тод байдал	
4.3 Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт	
4.4 Байгууллагын орон тооны бус салбар зөвлөл, комисс	
ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ	21-22
5.1 Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ	
ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ	23
ТУЛГАМДСАН АСУУДАЛ	24

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ нь Монгол улсын Засгийн газрын болон нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологи бүхий, экспортын чиг баримжаатай, импортын бүтээгдэхүүнийг орлох үйлдвэрлэлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар аж үйлдвэрийг хөгжүүлэх, шинээр ажлын байрууд бий болгох” үндсэн зорилго бүхий Багануур үйлдвэрлэл, технологийн парк байгуулах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

1.1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.1.11.3 - “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна.” арга хэмжээ

- БҮТП-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт /ХЕТ/ болон инженерийн дэд бүтцийн зураг төсөл иж бүрэн боловсруулж дууссан.
- Дэд бүтцийн бүтээн байгуулалтын нийт төсөв 173,152.09 сая төгрөг
- Улсын төсөв, Төр хувийн хэвшлийн түншлэл-80,578.8 сая төгрөг
- Нийслэлийн төсөв-80,578.8 сая төгрөгийг 2022-2024 оны хугацаанд санхүүжүүлэхээр тусгагдсан.
- Төслийн нийт эрчим хүчний хэрэглээ нь 63 МВт бөгөөд 2024 онд “Багануур повер” цахилгаан дулааны станцаас хангахаар төлөвлөгдсөн тул БҮТП-ийн удирдлагын зүгээс 2020 онд БҮТП-ийн төслийг тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор нэмэлт арга хэмжээ авсны үр дүнд ЭХЯ-наас 8 МВт хүчин чадал бүхий эрчим хүчний техникийн нөхцөл авч, 2021 онд дээрх эрчим хүчийг татаж авах 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамын зураг төслийг бүрэн дуусгах, дэд бүтцийн ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангахаар зорин ажиллаж байна.

1.2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахаар БҮТП-ийн 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, нийт 10 ажил тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр 2.2.5 Нүүрс болон нүүрсхимийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, 3.7.3 Хүнд үйлдвэрлэлийн чиглэлийн үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинээр парк байгуулах асуудлыг судалж, эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор хөгжүүлэх зэрэг зорилтуудын дагуу:

- БҮТП-ийн ХЕТ болон инженерийн дэд бүтцийн зураг төслийг иж бүрэн боловсруулсан.
- Дэд бүтцийг цогцоор нь байгуулах стратеги төлөвлөгөө боловсруулан ЗГ-ын болон нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны ҮАХ-т тусгуулан ажиллаж байна.
- Засгийн газраас Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, хэрэгжих хугацаанд УУХҮЯ-ны сайдтай 2017-2021 онд дунд хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтийг 87,1%-тай дүгнүүлсэн байна.

- Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг 2021 оны 6 дугаар сард ХХААХҮЯ-ны цахим системээр хүргүүлэн ажиллаж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021-2022 оны төлөвлөгөөг батлан эхний хагас жилийн тайланг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 67 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.

1.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 - “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийг байгуулна арга хэмжээнд Улс, нийслэлийн төсөв, Төр хувийн хэвшлийн түншлэлээр 6,000.0 сая төгрөгийг 2022-2024 оны хугацаанд санхүүжүүлэхээр тусгагдсан.

2021 онд паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын агаарын шугамын зураг төслийг бүрэн дуусгах зорилт тавин ажиллаж байна. Зураг төслийн нэгдсэн төсвийг ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төвийн төсвийн эксперт баталгаажуулсанаар магадлангийн нэгдсэн дүгнэлт гарч зураг төсөл бүрэн дуусна.

Дээрх үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөрүүдэд дэвшүүлсэн заалтуудыг хяналтад авч байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх бодлого, шийдвэр, зорилтуудыг 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгаж, түүний дагуу 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлан, 7 дугаар хавсралтын дагуу хагас жилийн тайланг нэгтгэн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 99 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тайлагнаж, нэгдүгээр улирал, хагас жилийн хэрэгжилтийн мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

2021 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 14 тогтоол, Ерөнхий сайдын 1 захирамж, нийт 26 зүйл заалтын хэрэгжилт 99.4%-ийн биелэлтэйгээр дүгнэгдэж мэдээ, тайланг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 96 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу нийслэлээс зохион байгуулагдсан архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын талаар мэдлэгийг дээшлүүлэх, баримт бичиг боловсруулах ур чадварыг сайжруулах чиглэлийн сургалтуудад Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн хамрагдаж, байгууллагын албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэхээр мэдээллийг хүргэн дотоод сургалтыг зохион байгуулан ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн Албан хэрэг хөтлөлтийн E-doc системийн ашиглалтыг сайжруулж, шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 2 дугаар хуралдааны тэмдэглэлийн 3 дахь хэсэгт заасанчлан тоон гарын үсэгт шилжих бэлтгэлийг хангаж, 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн eDoc системд бүрэн хэрэглэж хэвшсэн. eDoc, албан тушаалын систем дээрх ашиглагдахгүй байгаа, илүү үүсгэсэн, албан тушаалын нэр өөрчлөгдсөн хэрэглэгчийн мэдээллийг шинэчилсэн тухай мэдээллийг гарган 2021 оны 55 дугаартай албан бичгээр дүүргийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдааны биелэлтийг НЗДТГ-ын холбогдох мэргэжилтний ERP цахим хаягт 7 хоног бүр тайлагнан ажиллаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт

1. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны зохистой харьцааг хангах бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар, төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах саналыг ажилтан нараас авч нэгтгэн Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.

БҮТП-ийн 6 байршилд нийт 414,0 га газарт Багануур хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 2018-2020 онд хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төслийг иж бүрэн боловсруулж дууссан.

Энэхүү зураг төсөлд БҮТП-ийн үйл ажиллагааны үндсэн зорилт болох нийгэм, эдийн засаг, байгаль орчны зохистой харьцааг хангах бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар, төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг бүрэн тусгаж, 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдөр БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвийн №1193/2020 дугаартай магадлангийн нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан.

Төлөвлөгдсөн үйлдвэрүүдээс анхны төслийг “Монхимо” ХХК “Адуу” брэндийн үйлдвэрлэлээр хэрэгжүүлж, инноваци технологийн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

2. Хариуцсан ажил үүргийн чиглэлээр паркийн бүсийг хөгжүүлэх, төлөвлөх, орчноо тохижуулах үйл ажиллагаанд хувийн хэвшил, холбоод, аж ахуй нэгж байгууллагуудын оролцоог ханган, тэдний санал санаачилгыг хөгжлийн төсөл, хөтөлбөрт тусгах, хамтран ажиллах;

НШУҮИГ-ын даргын тушаалаар “Парк хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэх” ажлын хэсэгт дарга Ч.Элбэгсайхан ажилласан ба 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр НШУҮИГ-аас зохион байгуулсан “Парк хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэх” ажлын хэсгийн цахим хуралд оролцож, хэлэлцсэн асуудлаар холбогдох саналуудыг тусгаж, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын мөн өдрийн 44 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн.

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулсан.

2008 онд Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зориулалтаар тухайн үеийн ҮХЯ нь хувийн компаниас конторын барилгыг 1067 м.кв газрын хамт худалдан авсан байсан. Манай байгууллагаас уг барилгыг БҮТП-д шилжүүлэн авах асуудлыг архивлан эзэмшиж байсан УУХҮЯ болон ТӨХ-нд хандаж улмаар УИХ, ТӨХ, НЗД-ын шат шатны тогтоол, шийдвэр захирамжууд гарч, байгууллагын өмчид бүртгэн хүлээж авсан. Уг барилгыг капитал зэрэглэлээр засварлаж, Эрдэм шинжилгээ, судалгааны инкубатор, инновацийн төв /ЭШСИИТ/-ийг ажиллуулахаар төлөвлөсөн.

Паркийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу ЭШСИИТ-ийг байгуулахтай холбогдуулан барилгын засварын төсвийг гаргасан.

Мөн дээрх төвийн барилгын зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөлд тусгах саналыг албан бичгээр НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс болон Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газарт хүргүүлсэн. Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулахаар саналыг хүргүүлсэн.

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 295, 104 дүгээр тогтоолуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон их дээд сургууль, ЭШБ-уудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд компост бордоонд орох түүхий эдийг өвлийн улиралд бэлтгэх аргачлалын судалгаа туршилтыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнд Хөлдөөх, хатаах, ангилан ялгах гэсэн 3 арга боловсруулсан.

ШУТИС-аас эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээний ажил, шинэ бүтээл болон паркад нэвтрүүлж болохуйц судалгаа бүтээлийг цахим мэдээллийн хэрэгсэл ашиглан судалж байгууллагын мэдээллийн санд нэгтгэх ажлыг зохион байгуулсан.

Мөн УХЭШХ, ХААИС, ШАУИС, ШУТИС -тай 2019-2020 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж 2020 оны биелэлтийг хамтран дүгнэх ажлыг 2021 оны 02 дугаар сард цахимаар зохион байгуулсан. Цаашид инновацийн төслүүдийг хамтран боловсруулах, солилцох чиглэлээр хамтран ажиллахаар зорьж байна.

Бор-Өндөр Мандал ХХК-аас ирүүлсэн хайлуур жонш, нүүрс, төмөр, каолин, цахиур зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах, баяжуулах аж үйлдвэрүүдийн төслүүдэд судалгаа хийсэн.

Паркийн нэгжээр элсэх хүсэлтэй үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагч нарыг шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажилласан. Үүнд:

- Иргэн Д.Цолмон
- Иргэн н.Доржсүрэн
- Иргэн н.Бямбадорж
- Иргэн н.Мижиддорж (цахимаар)
- Иргэн Б.Бямбацогт (Үхрийн мах нийлүүлэх хүсэлтэй, цахимаар)
- Тэмүүжин металл ХХК, н.Амарсанаа (утсаар холбогдсон.)
- Мөнгөнзаяа ХХК-ийн төлөөлөл (цахимаар)
- Бор-Өндөр Мандал ХХК-тай биечлсэн уулзсан.
- Сүхбаатар аймгийн ЗДТГ болон Үйлдвэрлэл, технологийн паркийн төлөөлөл

3. Үйлдвэрлэл, технологийн паркийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нарийвчлан тооцсон хөгжлийн үе шатны төлөвлөгөө боловсруулан “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын Удирдах Зөвлөлөөр оруулж батлуулах;

Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр дараах төсөл хөтөлбөрт тусгуулахаар саналыг боловсруулж НШУҮИГ, НЗДТГ-т хүргүүлсэн. Үүнд:

- Нийслэлийн 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн саналд,

- Монгол Улсын болон нийслэлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд,
- Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн жагсаалтын саналд,

Азийн хөгжлийн банкны “2021-2024 онуудад Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналыг боловсруулан tubprmd@gmail.com цахим хаягаар 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хүргүүлсэн.

НШУҮИГ-ын дарга, мэргэжилтнүүдтэй 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр цахим зөвлөгөөн хийж, Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг хэлэлцэж, НЗД-ын Удирдах Зөвлөлийн хуралд оруулах саналуудаа танилцуулсан.

2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугамын зураг төслийг гүйцэтгэгч Мон-Энержи Консалт ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдтэй цахим хурал зохион байгуулж, Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоололыг нягтлан хянаж, санхүүжилтийн зардлын нарийвчилсан төсвийн саналыг Сангийн яамны холбогдох мэргэжилтний ERP хаягт хүргүүлсэн.

Сангийн яамны цахим системд байгууллагын 2022 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн жагсаалтыг 04 дүгээр сарын 23-ны өдөр шивж дуусгасан.

Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах “Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж”-ийн санал авч байгаатай холбогдуулан саналыг хавсралт маягтын дагуу боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр nzdtghbth2020@gmail.com цахим хаягт илгээсэн.

2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр НШУҮИГ-аас зохион байгуулсан цахим хуралд Газрын дарга оролцон дараах асуудлуудын талаар санал дэвшүүлсэн.

1. ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулах ажлыг эрчимжүүлэх,
2. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан Байгууллагын дүрмийн тодорхой заалтуудыг шинэчилж, нэмэлт өөрчлөлт оруулах,
3. НИТХ-ын 133 дугаар тогтоолоор батлагдсан “Парк хөгжүүлэх хөтөлбөр”-ийг шинэчлэх,

Мөн дээрх саналуудтай холбогдох материалуудыг ERP цахим хаягаар НШУҮИГ-т илгээсэн. Үүнд:

1. ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найрууллагын төсөл,
2. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон түүний Тэргүүлэгчдийн тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан журмуудын хэрэгжилтэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг өөрчлөх, шинэчлэх саналыг заалт тус бүрээр тусгасан жагсаалт,
3. Парк хөгжүүлэх хөтөлбөр,
4. НИТХ-аар хэлэлцүүлэх саналуудын жагсаалт

4. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган Нийслэлийн Засаг Даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах:

Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг хангах 2017-2020 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж дууссан.

Хөгжлийн II шатны Стратеги төлөвлөгөөг 2021-2024 оноор боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд БҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах ажлыг зохион байгуулан дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд:

- НЗДТГ-аас 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 03/841 дугаартай албан бичгээр өгсөн “Төрийн захиргааны төв байгууллагуудад хандах албан хэргүүдийг Нийслэлийн дээд шатны холбогдох байгууллагаар дамжуулан шийдвэрлүүлэх” үүрэг чиглэлийн дагуу байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн.

- НШУҮИГ болон НЗДТГ-ын хүсэлтийн дагуу технологийн түвшний үнэлгээ, ТЭЗҮ, паркийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, Байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээ зэрэг материалыг НШУҮИГ-т, анх паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байсан УУХҮЯ-тай хамтран ажилласан 4 жилийн гэрээний тайлан, байгууллагын 2017-2020 оны үйл ажиллагаанд ХШҮХ-ээс хийгдсэн шалгалтын дүгнэлтүүдийг НЗДТГ-т цахим хаягаар тус тус хүргүүлсэн.

НЗДТГ нь ХХААХҮЯ-нд холбогдох материалыг хавсарган албан бичгээр паркийн тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг уламжилсан.

Одоогоор ХХААХҮЯ-ны нэгдсэн системээр холбогдох материалыг цахим бүртгэлд оруулан БҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг хүргүүлээд байна.

5. Паркийн дэд бүтцийн техникийн нөхцөлүүдийг нарийвчлан судалж, холбогдох бичиг баримт материалууд, зураг, схемүүдийг бүрдүүлж, паркийн эрчим хүч, дулаан, усан хангамж зэргийн хэрэглээний нийт тооцоог гаргаж, хот байгуулалт, инженерийн байгууламжийн төлөвлөгөөтэй уялдуулан инженерийн тооцоо зураглал боловсруулах ажлыг зохион байгуулах;


Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийн урьдчилсан тооцоогоор паркийн 414,0га эзэмшил газрын дэд бүтцийн хөрөнгө оруулалтад 173,15 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Паркийн цахилгаан хангамжийн зураг төслийн ажлын явц:

1. Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан 20/02 тоот хамтран ажиллах гэрээний дагуу паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон үндсэн дэд станц болох 110/35кВ-ын зураг төслийг ЭХЯ-наас олгосон техникийн нөхцөлийн дагуу боловсруулж ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөж, нэмэлт өөрчлөлтийг оруулан баталгаажуулж, ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төвийн магадлангаар хянагдан баталгаажсан.

Улаанбаатар хот, Багануур дүүрэг
**220/110/35кВ-ын "БАГАНУУР" дэд станцын
 өргөтгөл**

/Ажлын зураг/

ЭВШВӨРСӨН			БОЛОВСРУУЛСАН		
	ЦДҮС ТӨХК-ийн ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ, ЕРВНХИЙ ИНЖЕНЕР	Нэр	Гарын үсэг		Гүйцэтгэгч
		Б. ДАШДАВАА			
			"МОН-ЭНЕРЖИ КОНСАЛТ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ		
			Л.ЭРДЭНЭДАЛАЙ		
			Захиалагч		
	ЦДҮС ТӨХК-ийн ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ, ЕРВНХИЙ ИНЖЕНЕР	Нэр	Гарын үсэг		Албан тушаал
		Б. ДАШДАВАА			
			"БАГАНУУР УТП" ОНВААТУГ-ийн ДАРГА		
			Ч.ЭЛБЭГСАЙХАН		

УЛААНБААТАР ХОТ 2021 ОН

Улаанбаатар хот, Багануур дүүрэг
110/35/10кВ-ын "БҮТП" дэд станц

/Ажлын зураг/

ЭВШВӨРСӨН			БОЛОВСРУУЛСАН		
	НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР НОБГ-ЫН ГАЛ ТҮЙМРИЙН ҮЛСЭН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДЭД ХУРАНДАА	Нэр	Гарын үсэг		Гүйцэтгэгч
		Л.ТЭГШБАЯР			
			"МОН-ЭНЕРЖИ КОНСАЛТ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ		
			Л.ЭРДЭНЭДАЛАЙ		
			Захиалагч		
	ЦДҮС ТӨХК-ийн ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ, ЕРВНХИЙ ИНЖЕНЕР	Нэр	Гарын үсэг		Албан тушаал
		Б. ДАШДАВАА			
			"БАГАНУУР УТП" ОНВААТУГ-ийн ДАРГА		
			Ч.ЭЛБЭГСАЙХАН		

УЛААНБААТАР ХОТ 2021 ОН

Улаанбаатар хот, Багануур дүүрэг

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨААТҮГ, "МЕСЕС"ХХК-НИЙ ГАДНА ЦАХИЛГААН
ХАНГАМЖИЙН 110кВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ

/Ажлын зураг/

Захиалагч			Гүйцэтгэгч		
Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Албан тушаал	Нэр	Гарын үсэг
 "БАГАНУУР ҮТП" ОНӨААТҮГ-ИЙН ДАРГА	Ч.ЭЛБЭГСАЙХАН		 "МОН-ЭНЕРЖИ КОНСАЛТ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ	Я.ЭРДЭНЭДАЛАЙ	

УЛААНБААТАР ХОТ 2021 ОН

2. Паркийн үндсэн 110/35кВ-ын дэд станцаас Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулагдах цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 35кВ-ын агаарын шугам болон 35/10кВ-ын төмөрлөг дэд станцын зураг төслийг Мон-Энержи Консалт ХХК-аар гүйцэтгүүлэн, 2021 оны 02 дугаар сарын 10-наас 02 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд Багануур дүүргийн ЗӨБС ЦДҮС ТӨХК, Дүүргийн ГЗБА, ЗӨБЦТС ТӨХК зэрэг дэд бүтцийн хангагч байгууллагуудын холбогдох дарга, мэргэжилтнүүд БҮТП ОНӨТҮГ-ын даргатай зөвшилцөж гарын үсэг зурж баталгаажуулж, ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төвийн магадлангаар хянагдан баталгаажсан.

Дээрх зураг төслүүдэд нэгдсэн дүгнэлт гаргуулахаар ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төвд хүргүүлсэн.



"МОН-ЭНЕРЖИ КОНСАЛТ" ХХК

**Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 35/10 кВ-ын
"Төмөрлөг" дэд станц**

Ажлын зураг



Дэвтэр IV. РП-10,11,12 хуваарилах байгууламж,
10кВ-ын ЦДКШ-ын трассын байгуулалт

Шифр: ME K18-01-IV

2020 он

ШИФР: МЭК-01/18

Улаанбаатар хот, Багануур дүүрэг
35/10кВ-ын "Төмөрлөг" дэд станц
 /Ажлын зураг/

ЗӨВШӨӨРСӨН			БОЛОВСРУУЛСАН			
НӨГСӨЛӨЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР  НӨБГ-ын гал туйврийн улсын хяналтын өлөх байцагч дэд хуандаа			Нэр Л.Тэгшбаяр	Гарын үсэг	Гүйцэтгэгч Албан тушаал "Мон-Энержи консалт" ХХК-ий захирал	Нэр Л.Эрдэнэсүх
"УБЦТС" ТӨХК  "УБЦТС" ТӨХК-н техникийн асуудал эрхэлсэн дэд захирал			Нэр Л.Ганзориг	Гарын үсэг	Захиалагч Албан тушаал "Багануур УТГ" ОНБААТУГ-ийн дарга	Нэр Ч.Энбасайхан

УЛААНБААТАР ХОТ 2020 ОН

6. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг баримтлах;

Паркийн нэгж "Монхимо" ХХК нь байгаль орчинд халгүй дэвшилтэт нано технологиор, хүний эрүүл мэндэд чиглэсэн Адуу брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Одоогийн байдлаар "Монхимо" ХХК нь Ковид-19 цар тахалтай холбоотой бүтээгдэхүүнээ экспортлох ажлыг түр зогсоон дотоодын хэрэгцээнд нийлүүлэлт хийн ажиллаж байна.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн компост бордоог ашигласан "Багануур тохижилт" байгууллагын төв магистраль автозам дагуух хамгаалалтын зурвасын 110 ш модны ургалтын явцад 2021 оны 06 дугаар сард хяналт тавьсан.

Мөн 2021 оны 06 дугаар сард 2019-2020 онуудад үзүүлэх сургалт хийсэн 5 айл өрхийн компост бордооны явцыг ковид-19 цар тахалтай холбоотойгоор цахимаар болон утсаар холбогдон зөвлөгөө өгч ажилласан.

7. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх талаар гаргасан хууль, тогтоомж, шийдвэр, төлөвлөсөн бодлого, авч буй арга хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, түүний үр дүнгийн талаар олон нийтэд сурталчлах;

Байгууллагад мөрдөгдөж буй хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэж байна.

Мөн ковид-19 цар тахалтай холбогдон гарч байгаа тогтоол, шийдвэр, захирамжийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж байна.

8. Гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож ажиллах;

Зүүн бүсийн аймгуудын удирдлагатай харилцаа холбоо тогтоож, Паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах, санамж бичиг байгуулах үүднээс Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 71, 72, 73 дугаартай хамтран ажиллах тухай албан бичгийг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн.

Дээрх албан бичгийн дагуу Сүхбаатар аймгийн ЗДТГ болон ҮТП-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан.

Мөн Бор-Өндөр Мандал ХХК, Сүхбаатар, Налайх, Багахангай ҮТП-уудтай туршлага солилцох арга хэмжээг цахимаар зохион байгуулан ажилласан.

Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газраас цахим уулзалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Үйлдвэрлэл, технологийн паркуудтай 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр хамтран зохион байгуулсан. Тус уулзалтаар яамдын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулж төлөвлөгөө гаргаж ажиллахаар ажлын хэсэг байгуулах тухай НЗД-ын 2021 оны А/483 дугаар захирамж гарсан. Уг захирамжийн дагуу хамтарсан төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан 102 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.

3.2. Архив, Албан хэрэг хөтлөлт

Архивын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

2021 оны 1 дүгээр улиралд байгууллагын 2020 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн Байнга хадгалах 42, Түр хадгалах 51, 70 жил хадгалах 6, Тусгай төрлийн 2 баримтыг архивт хүлээн авах хуваарь болон 2020 оны ХХНЖ-ийн дагуу хүлээн авч бүртгэлжүүлэв. Мөн 2020 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн захирамжлалын баримт бичгүүдийг **archive.edoc** программд оруулж нэгтгэн бүртгэлжүүлсэн.

2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т нийт 106 бичиг ирснээс хариутай бичиг 53, хариугүй 53, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 99,22%-тай байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2,90 хоног. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар яам, нийслэл, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 102 албан бичиг явуулсан.

Баримт бичгийн шийдвэрлэлтийн байдлыг алба тус бүрээр графикаар харуулав.

Хэлтэс нэгж	Ирсэн бичгийн тоо		Ирсэн шийдвэрлэлтийн хувь		Явуулсан бичгийн тоо	Явуулсан бичгийн шийдвэрлэлтийн хувь	Албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хугацаа
	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь	Хариугүй бичгийн шийдвэрлэлтийн хувь			
Удирдлага	1	4	100%	100%	0	100%	0.75
Захиргааны алба	43	38	98,84%	100%	85	100%	3.37
Үйлдвэрлэл, технологийн алба	9	11	100%	100%	17	100%	1.45
НИЙТ	53	53	99,02%	100%	102	100%	2.90
	106		99,22%				

3.3. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2021 оны эхний хагас жилийн байдлаар/

2021 оны 06 дугаар сарын 29

Багануур дүүрэг

Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо					Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр			Өргөдлийн төрөл				
			Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	1-10 хоногт	11-20 хоногт	21-30 хоногт	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо	Албан бичгээр	Утсаар	Биечлэн уулзах	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Ажил хүссэн	1			1							+			+		
2	Дэмжлэг туслалцаа хүссэн																
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой																
4	Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл	1			1							+			+		
5	Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл																
6	Бусад																
	Нийт	2			2							2			2		

Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

№	Ангилал	Тоо	Шалтгаан, тайлбар
0	1	2	3
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	2	- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т жолооч ажилтай Намсрайн Жаргалсайханы ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. - “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т жолоочоор ажиллаж байсан Дамбачимэдийн Бат-Эрдэнэ Хэнтий аймгаас нүүн ирж эргээд ажиллах боломжтой болсон тул ажилд орох хүсэлт гаргасан.
2	Боломжгүй тухай хариу өгсөн	-	-
3	Бусад	-	-

3.4. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	15	23	
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	5	7	
			Мэргэшүүлэх сургалт	-	1	
			Туршлага солилцох арга хэмжээ	2	4	
			Бусад	10	11	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	10	9	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	5	4	
			Эрэгтэй албан хаагч	5	5	
			Удирдах албан тушаалтан	1	1	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	90			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	-	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	Эхний хагас жилийн гүйцэтгэлээр
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	13,6	

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	63,6	Эхний хагас жилийн гүйцэтгэлээр
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-	5000	Хоногт олгохоор тогтоосон дүн
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	100	
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	-	Төрөлжсөн болон багц шинжилгээ
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	90	Сайн дураар хамрагдах
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	Эхний хагас жилийн гүйцэтгэлээр

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Үйл ажиллагааны ил тод байдал

2021.03.15-ны өдөр нийслэлийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс ирүүлсэн 61 дүгээр зөвлөмжөөр паркийн цахим хуудасны мэдээллийн ил тод байдал 90,0% үнэлэгдсэн нь 2020 оноос 8,4%-аар өссөн үзүүлэлттэй гарсан.

Дээрх өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 45 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд баяжилтийг тогтмол хийж, ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

Мөн корона вирусын цар тахалтай холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, цаг үеийн мэдээ, тогтоол, шийдвэр зэргийг байршуулж байна.

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж Байгууллагын цахим хуудасны шилэн данс цэсээс шилэн дансны мэдээллийг татах, хэвлэх боломжтой болгосон.

Мөн www.shilendans.mn сайтад агуулга стандартын дагуу байгууллагын мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, бодлогын баримт бичгийн дагуу хэрэгжүүлж төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан.

Нийслэлийн Төрийн аудитын газраас байгууллагын 2020 оны санхүү, НББ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Зөрчилгүй” дүгнэлт гаргаж гэрчилгээ хүлээн авсан.

4.2. Хүний нөөцийн ил тод байдал

Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журам” А/1054 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

БҮТГ-ийн даргын 2021 оны А/01 дугаартай тушаалаар бүтэц орон тоо, албан тушаалын чиг үүрэг, цалингийн сүлжээг баталсан. 2021 оны эхний хагас жилийн байдлаар хүний нөөцтэй холбоотой Б тушаал - 15 гарсан.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээг тухай бүр гарган байгууллагын вэб сайт болон мэдээллийн самбарт байршуулсан.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн мөн ЗГ болон НЗДТГ-аас өгч байгаа албан тушаалын чиг үүрэг, хэрэгжилт, хяналтыг сайжруулах, хийдэл давхардлыг арилгах тухай албан даалгавруудыг харгалзан үзэж, 2 инженерийн орон тоог хавсран гүйцэтгүүлж байна.

Мөн цаг үеийн байдлын улмаас Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.2 дахь заалтын хэрэгжилтийг ханган 1 инженер, 1 мэргэжилтний орон тоог хавсруулан гүйцэтгүүлж байна.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ажил хүлээлцэх журам”-ыг мөрдлөг болгон ажилласан бөгөөд 2021 оны хагас жилийн байдлаар нийт 3 ажил хүлээлцэх хуудас хөтөлсөн байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу байгууллагын нийт албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлж баяжуулалт хийсэн ба 2021 онд шинээр ажилд орсон 1 албан хаагчийн хувийн хэргийг мөн хавсралтын дагуу бүрдүүлсэн.

ERP системийн “Хүний нөөцийн удирдлага” дэд системд байгууллагын албан хаагч бүрийн хувийн хэргийн бүрдлийг цахимаар шивж оруулсан. Мөн ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн системд нэвтрэх эрхийг хааж, шинээр ажилд томилогдсон албан хаагчид шинэ бүртгэл үүсгэн ажилласан.

Мөн ERP систем дэх албан хаагчийн алдаатай бүртгэлийг зассан.

4.3. Байгууллагын орон тооны бус салбар зөвлөл, комисс

Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-т дараах орон тооны бус салбар зөвлөл, комиссын бүрэлдэхүүн ажиллаж байна.

- Даргын зөвлөл
- Ёс зүйн зөвлөл
- Дотоод хяналт шалгалтын комисс
- Баримт бичиг нягтлан шалгах комисс
- Өмч хамгаалах байнгын комисс
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар зөвлөл
- Спорт, эрүүл мэндийн салбар зөвлөл
- Залуучуудын хөгжлийн зөвлөл

4.4. Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт

Байгууллагын үндсэн хөрөнгө, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр тоолж хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьдаг. 2021 оны эхний хагас жилийн тооллогыг Газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/12 дугаар тушаалаар зохион байгуулж ажилласан ба тооллогоор:

Үндсэн хөрөнгө 244,973,499 төгрөг,
Аж ахуйн материал 1,736,600 төгрөг,
Бусад хангамж 3,952,500 төгрөг,
Бичиг хэрэг 936,000 төгрөг,
Цэвэрлэгээ ариутгал 1,175,300 төгрөг тус тус тоологдсон.

4.5. Нийгмийн хариуцлагын хүрээнд

Багануур дүүргийн Захирагчийн ажлын албанаас 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээнд хамт олноороо идэвхтэй оролцож хуваарилсан газрыг цэвэрлэж, тайланг хүргүүлэн ажилласан. Үүнд:

- 2021.02.05 - “Хоггүй шинэлцгээе” аяны хүрээнд Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ
- 2021.03.19 - Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ

- 2021.04.22 - “Их цэвэрлэгээ – 90 минут” бүх нийтийн их цэвэрлэгээ
- 2021.05.23-ны өдөр “Бүх нийтээрээ цэвэрлэгээнд нэгдье” уриатай ногоон бүсийн цэвэрлэгээ
- 2021.06.26-ны өдөр “Шарилжгүй Улаанбаатар-6” аяны хүрээнд зохион байгуулагдсан хуваарьт талбайн шарилж устгал

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 дүгээр захирамжийн дагуу Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заагдсанаар мөнгөн хандивыг цуглуулж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан тухай мэдээг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 63 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд хүргүүлсэн.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/1421 дугаар албан бичгийн хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өгөөмөр өдөр” арга хэмжээг байгууллага дээрээ зохион байгуулж, ажилтан албан хаагчдын дунд хүн хэрэглэх боломжтой эд зүйлсийг цуглуулж, бүртгэл хөтлөн жагсаалтын хамт Багануур дүүргийн 1 дүгээр хороонд 06 дугаар сарын 23-ны өдөр хүлээлгэн өгсөн.



ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдон гарсан Засгийн газрын 2, 27, 45, 91, 105 дугаар тогтоол, НЗД-ын А/06, А/85, А/86, А/87, А/161, А/221, А/246, А/265, А/313 дугаар захирамжуудын хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.

НОК-ын 2021 оны 06 дугаар цахим хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Дэм дэмэндээ” аяныг 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, тайланг ERP системээр тайлагнасан.



Мөн паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-тай хамтран “Дэм дэмэндээ” аяныг үргэлжлүүлэн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж, зорилтот бүлгийн 10 айл өрхөд хүнс тэжээлийн туслалцаа үзүүлэхээр харьяа 1 дүгээр хороонд хүнсний бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгсөн.



Нийслэлд ковид-19 цар тахал хурдацтай нэмэгдэж хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор НОК-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” үйл ажиллагаанд Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, хорооны албан хаагч нартай хамтран ажиллаж, илтгэх хуудсыг 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.

Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу ЗГ-ын 2021 оны 45 дугаар тогтоол, УОК-ын 2021 оны 18 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, 03 дугаар сарын 01-31-нийг хүртэлх хугацаанд Багануур дүүргийн Онцгой комиссын шуурхай штабын даргын чиглэлээр бичиг хэргийн ERP хаягт өдөр бүр биелэлтийг хүргүүлэн ажилласан.

2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд мэдээг шинэчлэн НЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажиллаж байна.

Одоогоор Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоол, НЗД-ын А/477 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллаж байна.

Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Ажилтнуудыг амны хаалт, паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн болох ам хоолой, зайлах уусмал, гар ариутгагч санитолоор ханган ажиллаж байна.
- Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна.
- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг зааврын дагуу хэвлэн иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна.
- "Ковид 19 эрсдэл систем"-ийг бүх албан хаагчдад гар утсандаа суулган ашиглаж байна.
- Байгууллагын бүх албан хаагчид дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан.
- Халдвар авсан албан хаагч байхгүй.

ДҮГНЭЛТ

Байгууллагын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд эхний хагас жилийн байдлаар амжилттай хэрэгжүүлсэн.

Хэдийгээр ковид-19 цар тахлын улмаас бүх талын нөхцөл байдал хүндэрч байгаа боловч, нийт хамт олон албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, хичээл зүтгэл, бусад байгууллагуудтай хамтран ил тод, нээлттэй зарчмаар хамтран үр дүнтэй ажилласан.

ЦААШДЫН ЗОРИЛТ

Тайлант онд Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1. “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг УИХ-д эцэслэн батлуулах шаардлага нэн чухал байна.
2. Хууль батлагдсаны дараа төрийн захиргааны төв байгууллагуудаас дагалдан гарах журмуудыг баталж гаргуулах
3. Үйлдвэрлэл, технологийн паркуудын статус, байгууллагын дүрэм, үндсэн зорилго, чиг үүрэг зэргийг дахин хянан үзэж шинэчлэх асуудлыг шийдвэрлэх

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА